

**“ЖИМС, ЖИМСГЭНЭ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
(2019 оны жилийн эцсийн байдлаар)**

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл			
1.	“Жимс, жимсгэнэ” үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2017 оны 223 дугаар тогтоол	Зорилго: Жимс, жимсгэнийн нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн чацарганын тариалалтыг 10 мянган га, бусад төрлийн жимс, жимсгэнийн тариалалтыг 2 мянган га талбайд хүргэж, хүн амыг экологийн цэвэр, амин дэм бүхий жимс, жимсгэнээр тогтвортой хангах, импортыг бууруулах, өрсөлдөх чадварыг сайжруулан экспортын орлогыг нэмэгдүүлэхэд зорилго оршино.			
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	Улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт			
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Хугацаа:2018-2022 он Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Аймаг, нийслэлийн ХХААГ, ХААДС Монголын жимс жимсгэнэ үйлдвэрлэгчдийн холбоо			
4.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1. Жимс, жимсгэнийн аж ахуйг хөгжүүлэх, таримлын болон бүтээгдэхүүний нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах эрх зүй, бизнесийн таатай орчинг бүрдүүлэх; Зорилт 2. Жимс, жимсгэнийн таримлын сорт шалгаруулах, анхдагч үржүүлэг, бойжуулга, суулгац үйлдвэрлэлийг бүсчлэн хөгжүүлж, ган, хүйтэн болон өвчин хортонд тэсвэртэй, нутагшсан сортын суулгацын хангамжийг нэмэгдүүлэх; Зорилт 3. Жимс, жимсгэнийн тариалалт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг инноваци, дэвшилтэт техник, технологи, шинжлэх ухааны судалгаанд суурилуулан цогц байдлаар хөгжүүлэх, салбарын хүний нөөцийг чадавхжуулах; Зорилт 4. Салбарын маркетингийн стратегийг боловсруулж, дотоод болон гадаадын хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг тодорхойлох, шинэ зах зээлд нэвтрэх ажлыг эхлүүлэх.			
5.	Үзүүлэлт	Төсөв (Нийт шаардаг дах зардал)	ХХААХҮ-ийн сайдын багцаас жимсний суулгац үржүүлэх хүлэмж авахад зориулж-147.0 сая, Жимс, жимсгэнэ дэд хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн хөрөнгө оруулалт 3,722.05 сая төгрөг 2019 оны нийт санхүүжилт 3,869.05 сая төгрөг		
		Үүнд:	Төсөв (он)	Гүйцэтгэл	Хувь
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилт:		Арга хэмжээний биелэлт		
	Зорилт 1.		Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн 58-65 дүгээр хуудсыг үзнэ үү.		
	Зорилт 2.		Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн 65-67 дугаар хуудсыг үзнэ үү.		
	Зорилт 3.		Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн 67-73 дугаар хуудсыг үзнэ үү.		
	Зорилт 4.		Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн 73-76 дугаар хуудсыг үзнэ үү.		
7.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	Жимс жимсгэнийн нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн хүн амыг экологийн цэвэр, амин дэм бүхий жимс, жимсгэнээр тогтвортой хангах, импортыг бууруулах, өрсөлдөх чадварыг сайжруулан экспортын орлогыг нэмэгдүүлэх зорилготой “Жимс жимсгэнэ” хөтөлбөрийг Засгийн газрын 2017 оны 223 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж байна. “Хөтөлбөрийн хүрээнд 2018-2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж ХХААХҮ-ийн Сайдын 2018 оны 07 дугаар 25-ны өдрийн А-128 дугаар тушаалаар батлуулж, хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд			

	<p>зохион байгуулж байна. Аймгуудад хэрэгжүүлж буй “Жимс, жимсгэнэ” дэд хөтөлбөрийн 2019 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд 410 гаруй ногоон ажлын байр шинээр бий болж, элсний нүүдэл, уул уурхайн нөхөн сэргээлтэд зориулж 850.3 га талбайд жимсний мод тарьж, 56.9 га байгалийн чацаргана, жимс жимсгэнийн талбай сэргээгдэж, орон нутгийн төсвөөс 3.7 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.</p> <p>Хөтөлбөрийн хүрээнд 2019 онд 181.06 га талбайд шинээр жимст цэцэрлэг байгуулсан байна. Улсын төсвөөс жимсний суулгац үржүүлэх хүлэмж авахад зориулж-147.0 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлэсэн бөгөөд орон нутгийн төсвийн санхүүжилтээс 25 дахин бага байна. Энэ нь ХХААХҮЯ-аас “Жимс жимсгэнэ” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлд тусгагдсан санхүүжилт туйлын хангалтгүй байгааг харуулж байна.</p> <p>2019 онд жимс жимсгэнийн талбай 6534.1 га –д хүрч, хураан авсан жимсний ургац 2604.1 тонн болов. 5000 кг жимс, шүүс, 10000 ширхэг бүтээгдэхүүн, 20 кг чацарганын тос экспортод гаргасан байна. Улсын хэмжээнд жилдээ 7323.3 тн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадал бүхий 45 үйлдвэр ажиллаж байна.</p> <p>Чацаргана, үхрийн нүд алим, чавга, интоор, бөөрөлзгөнө гэх мэт жимс, жимсгэнийн 515.3 мянган ширхэг суулгац эх орондоо үйлдвэрлэсэн байна.</p> <p>Хөтөлбөр батлагдсанаас ХХААХҮ-ийн сайдын багц, Жимс, жимсгэнэ дэд хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн хөрөнгө оруулалт, гадаадын төслөөс 2019 онд нийт 3,869.05 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.</p> <p>“Жимс, жимсгэнэ” үндэсний хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний ерөнхий гүйцэтгэл эхний жилийн байдлаар 71.2 хувьтай буюу өнгөрсөн оноос 5.4 хувиар илүү үнэлэгдлээ. Цаашид хөтөлбөрийн санхүүжилтийг нэмэгдүүлж хэд хэдэн зорилтын хүрээнд заасан ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.</p> <p>Эдгээр арга хэмжээний удааширсан, хэрэгжээгүй шалтгаан нөхцөлийг судалбал санхүүжилт, бэлтгэл ажил судалгааны түвшинд үр дүн хараахан гараагүй байгаа, хамтран хэрэгжүүлэгч зэргээс хамаарч байна.</p> <p>“Жимс, жимсгэнэ” үндэсний хөтөлбөрийн тайланд өнгөрсөн оны хэрэгжилтийн тайлагнасан, нэг биелэлтийг хэд хэдэн арга хэмжээний хэрэгжилтэд бичсэн, сайдын тушаалаар батлагдсан үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд заасан шалгуур үзүүлэлт, үр дүнгийн дагуу тайлагнаагүй зэрэг нь ХШҮ хийх явцад хүндрэл учруулж байсан.</p> <p>ЗӨВЛӨМЖ:</p> <ol style="list-style-type: none"> 1 “Жимс, жимсгэнэ” үндэсний хөтөлбөрийн 1 болон 3 дугаар зорилтын хэрэгжилт хангалтгүй байгаад дүн шинжилгээ хийж ажиллах, 2 Чацаргана хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгаад хангалтгүй хэрэгжсэн хэд хэдэн технологи нэвтрүүлэх, хүний нөөцийг тооцоо судалгаанд тулгуурлан чадавхжуулах, боловсруулах үйлдвэр байгуулах, экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэж, экспортлох чиглэлд онцгой анхаарах, 3 Жимс, жимсгэнэ хөтөлбөрийн зорилт, арга хэмжээнээс хэрэгжилт хангалтгүй буюу 40 хувиар үнэлэгдсэн дараах арга хэмжээг эрчимжүүлэх, Үүнд: Жимс, жимсгэнэ үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний <p>1.2. Чацаргана, бусад төрлийн жимс, жимсгэнийн бүтээгдэхүүнийг экспортлоход учирч байгаа саад тотгорыг арилгах, дотоод зах зээлийг импортын ижил төстэй бараа, бүтээгдэхүүнээс хамгаалах;</p>
--	--

		<p>1.6. Жимс, жимсгэнийн сортыг хянан баталгаажуулж, хяналт тавин мөрдүүлэх;</p> <p>1.8. Жимс, жимсгэнийн өртгийн сүлжээг хөгжүүлэх, түүний байршил, хамрах хүрээ, үе шат, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан бүс нутгийн нөөц, байгаль цаг уурын онцлог, дэд бүтэц, ложистик, жижиг, дунд үйлдвэрийн хөгжилтэй уялдуулан хэрэгжүүлэх;</p> <p>1.15. Монгол чацаргана бүтээгдэхүүний стандартыг тогтоох, түүнийг олон улсад баталгаажуулах, чацарганыг органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, брэнд болгон хөгжүүлэх;</p> <p>3.8. Өөрийн орны онцлогт тохирсон жимс, жимсгэнийн талбай, хүлэмжид усны зарцуулалт багатай усалгааны дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, хураалтыг механикжуулах;</p> <p>3.13. Мэргэжлийн ахисан түвшний хөтөлбөрүүдийг боловсруулж, эрчимжсэн, дунд, урт хугацааны сургалтыг мэргэжлийн байгууллагыг түшиглэн явуулж, мэргэжилтэй ажилтан бэлтгэх;</p> <p>4 Жимс жимсгэнэ үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөөнд 2019 оноос хэрэгжүүлж эхлэхээр тусгагдсан 3 ажлыг амжилттай хэрэгжүүлэх чиглэлд анхаарах, холбогдох төрийн болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллахыг тус тус зөвлөмж болгож байна.</p> <p>5 Үндэсний хөтөлбөрийн тайлангийн чанарыг сайжруулах, хэрэгжүүлэх арга хэмжээнд заасан шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнгийн дагуу тайлагнаж хэвших.</p>				
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ холбогдох яамд, төрийн байгууллага, ХААДС, дотоод, гадаадын төсөл, хөтөлбөрүүд, олон улсын байгууллагууд, Монголын жимс жимсгэнэ үйлдвэрлэгчдийн холбоо, хэвлэл, мэдээллийн байгууллагууд, аймгуудын ХХААГ, холбогдох эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар хангалттай сайн ажилласан гэж дүгнэж байна.				
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Биелэлт дундаж	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4
	Хяналт-шинжилгээ, үнэлгээ (Зорилт, арга хэмжээний үнэлгээ)	83.0%	70.0	100.0	80.0	82.0
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ				
		... %				

“Жимс, жимсгэнэ” үндэсний хөтөлбөрийн арга хэмжээний хэрэгжилтийн тайлан

Д/д	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2019 оны зорилгот түвшин	ХЭРЭГЖИЛТ	Үнэл -гээ
1. Жимс, жимсгэнийн аж ахуйг хөгжүүлэх, таримлын болон бүтээгдэхүүний нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах эрх зүй, бизнесийн таатай орчинг бүрдүүлэх;						
1	1.1. Жимс, жимсгэнэ тариалах, хураах, хадгалах, боловсруулах үйлдвэр байгуулах, шинэ техник, технологи, инноваци нэвтрүүлэх, шинжлэх ухааны судалгаа, шинжилгээнд санхүү, хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжлэг үзүүлэх, санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх;	2018 - 2022	1,818.4 сая төгрөг		АХБ-ны “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн нэмэлт санхүүжилт” төслийн хүрээнд 2018 онд Завхан аймгийн “Завхан баялаг” ХХК-д жимс жимсгэнийн тариалалт, боловсруулах үйлдвэрлэлийг өргөжүүлэхэд зориулан 1.088 тэрбум төгрөгийн 7 жилийн хугацаатай хөнгөлөлттэй зээл олгов. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2019 онд “Мон-адонис” ХХК-ийн “Жимс жимсгэнийн хуурай ханд үйлдвэрлэх” төсөлд 155.4 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон ба Улаанбаатар хотод БНСУ-ын хөрөнгө оруулалт, санхүүжилттэй “Ногоон Ази-сүлжээ” ТББ жилд 600 тонн чацаргана боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэв. Мөн ЖДҮХСангаас 2019 онд Архангай аймгийн “Зуслан гурван ган” ХХК-д 20.0 сая, Говь-алтай аймгийн иргэн Мянганцэцэгт 20.0 сая, Хөвсгөл аймгийн шинэ амттан ХХК-д 260.0 сая төгрөгийн зээл олгов. Өмнөговь аймгийн Даланзадгад сумын “Их говийн төгөл” ХХК-д орон нутгийн жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас 275.0 сая төгрөгийн зээл олгож жилд 40 тн шүүс ундаа, 100 литр чацарганын тос үйлдвэрлэх хүчин чадалтай “Чацаргана боловсруулах” цех ашиглалтанд оруулав. НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн бизнесийн орчин сайжруулах бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын “Чацаргана төгөл” хоршооны чацаргана боловсруулах цех байгуулах 50 сая төгрөгийн зээлийн төсөлд дэмлэг үзүүлсэн байна.	100%
2	1.2. Чацаргана, бусад төрлийн жимс, жимсгэнийн бүтээгдэхүүнийг экспортлоход учирч байгаа саад тотгорыг арилгах, дотоод зах зээлийг импортын ижил төстэй бараа, бүтээгдэхүүнээс хамгаалах;	2019 - 2022			Европын холбооны санхүүжилтээр хэрэгжиж буй “Монголын худалдааг дэмжих” TRAM төслийн хүрээнд “Чацарганын кластер байгуулах” төсөл хэрэгжүүлж чацарганын кластерт оролцогчдыг бүртгэлжүүлэн хамтын санамж бичиг байгуулан, удирдах зөвлөлийг сонгож хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргав. 2020 оны 1 дүгээр сард Герман улсад зохиогдсон Green week хүнсний бүтээгдэхүүний олон улсын үзэсгэлэнд тус төслөөс 11.0 мянган еврогийн санхүүжилт зардал гарган стенд түрээсэлж чацаргана боловсруулах 4 үйлдвэрийн бүтээгдэхүүнийг оролцуулж олон улсад сурталчлав. Экспортыг дэмжих зорилгоор Герман улсад Монгол бүтээгдэхүүний нэрийн дэлгүүр ажиллуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж эхлэв. БНСУ-тай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулахаар бэлтгэл ханган ажиллаж байгаа бөгөөд жимс жимсгэнийн бүтээгдэхүүний БНСУ-ын импортыг татварыг бууруулах чиглэлээр ажиллахаар төлөвлөж байна.	40%

3	1.3. Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон улстай байгуулсан хэлэлцээр болон бусад улстай байгуулах чөлөөт худалдаа, олон талт хэлэлцээрт гэдгээр орны зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх гол бараа, бүтээгдэхүүний нэр төрөлд жимс, жимсгэнийн бүтээгдэхүүнийг нэмж оруулах асуудлыг судлан шийдвэрлэх;	2022			Хугацаа болоогүй	Үнэлэх боломжгүй
4	1.4. Шинээр тариалж, ургуулан үр жимсээ тогтвортой өгч эхэлсэн мод, бутны тоогоор таримлын төрлөөс хамааруулан нэг удаагийн урамшуулал олгох;	2020 - 2022			Хугацаа болоогүй. 2020 оноос хэрэгжиж эхэлнэ	Үнэлэх боломжгүй
5	1.5. Жимс, жимсгэнийн талбайг хашаажуулах, ойн зурвас байгуулах, усалтын систем шинээр байгуулах, орчин үеийн дуслын усалгааны тоног төхөөрөмж суурилуулах, тариалалт, хөрс боловсруулалт, хураалтыг механикжуулах, суулгац худалдан авах иргэд, аж ахуйн нэгжид санхүүгийн болон хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх;	2018 - 2022			Жимс жимсгэнийн талбайд ойн зурвас байгуулах стандартын төсөл боловсруулав. 2020 онд стандартын хороогоор хэлэлцүүлэх төлөвлөгөөнд оруулсан ба батлуулахаар ажиллаж байна. Шинэ хөдөө төслийн хүрээнд 2019 онд 239.2 сая төгрөгийн санхүүжилтээр Булган аймгийн 7 суманд тус бүр 10 га талбай бүхий нийт 70 га талбайд жимс жимсгэнийн дуслын усалгааны төхөөрөмж нийлүүлж суурилуулав. Тус төслийн хүрээнд сүүлийн 2 жилд 8 суманд жимст цэцэрлэгийн талбай байгуулан нийт 50 мянган ширхэг чацаргана, 15.0 мянган ширхэг үхэр нүдний суулгац зээлээр олгон тариалуулж 11 сумын 150 га чацарганын талбайд орчин үеийн дэвшилтэт дуслын усалгааны систем суурилуулж усалгаажуулав. Энэхүү төсөл хэрэгжсэнээр хөдөө орон нутагт жимс жимсгэнэ, хүнсний ногоо, бусад үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд бодитой ажлууд хийгдэж бусад аймгуудад хэрэгжиж боломжтой загвар төсөл гэж тус яамнаас сайшаан үнэлэв. БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр 2019 онд 90 ширхэг нийт 270 га жимс жимсгэнийн талбайг услах дуслын усалгааны системийг нийлүүлж ХААДС-аар дамжуулан зээлээр олгож байна. 2019 онд ашигт малтмалын хайгуул, ашиглалт явуулсан 527 га талбайд нөхөн сэргээлт хийсний зэрэгцээ 56 га байгалийн жимс жимсгэнийн талбайг хашаажуулж хамгаалалтад авсан байна. Улсын төсвийн 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2019 онд Ховд аймгийн Булган, Жаргалант суманд жимс жимсгэнийн суулгац үржүүлгийн төвийг анх удаа байгуулав. Энэхүү ажлын хүрээнд Булган суманд 3.2 км усалтын систем байгуулан 1500 ширхэг жимс жимсгэнийн мод тариалж суулгац үржүүлгийн эх цэцэрлэг байгуулан, 1000 ширхэг бургасаар ойн зурвас байгуулав. Жаргалант суманд 10 га талбайд бетонон суурьтай төмөр торон хашаа, усалтын системийн толгойн барилга, усалгааны сувгийн ажлыг гүйцэтгэв.	100%
6	1.6. Жимс, жимсгэнийн сортыг хянан баталгаажуулж, хяналт тавин мөрдүүлэх;	2019			Жимс жимсгэнийн сортыг хянан баталгаажуулах арга зүй техникийн шаардлагын төслийг боловсруулав. Газар тариалангийн стандарчиллын хорооны 2020 оны ажлын төлөвлөгөөнд тусгуулсан ба ондоо багтааж 2 удаа хэлэлцүүлж батлуулахаар төлөвлөж байна. Үр сортын тухай хууль батлагдсаны дараа хэрэгжүүлж эхэлнэ.	40%
7	1.7. Жимс, жимсгэнэ тариалж ажлын байр	2019 - 2022			2019 онд Монголын жимс жимсгэнийн үндэсний холбоотой хамтран “Чацаргана ба	70%

	олгосон иргэдэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл, хөтөлбөр, зээлд хамрагдахад дэмжлэг үзүүлэх, тэдний мэдлэг, ур чадварыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулах;			бусад жимс жимсгэнийн тариалалт, арчилгаа”, “Алим тариалах, залгуургын аргаар суулгац үржүүлэх”, “Чацаргана ба бусад жимс жимсгэнийн өвчин, хортон шавж, амьтан тэдгээрээс урьдчилан сэргийлэх ба тэмцэх арга”, “Жимс жимсгэнэ, гоёл чимэглэлийн мод бутны үржүүлэг”, “Жимс жимсгэнийн таримлын органик баталгаажуулалт” зэрэг 5 төрлийн сургалт зохион байгуулж 100 гаруй жимс жимсгэнэ тариалагчид, үйлдвэрлэгчдийн мэдлэг чадварыг дээшлүүлэв. АХБ-ны төслийн санхүүжилтээр Увс, Төв аймагт чацарганын тариаланд ХАА-н зохистой дадал нэвтрүүлэх, талбайд хавар, зуны улиралд хийх агротехникийн арга ажиллагааны сургалт зохион байгуулж нийт 138 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулав.	
8	1.8. Жимс, жимсгэнийн өртгийн сүлжээг хөгжүүлэх, түүний байршил, хамрах хүрээ, үе шат, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан бүс нутгийн нөөц, байгаль цаг уурын онцлог, дэд бүтэц, ложистик, жижиг, дунд үйлдвэрийн хөгжилтэй уялдуулан хэрэгжүүлэх;	2019 - 2021		Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй “Хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг дэмжих” техник туслалцааны төслийн “Чацаргана” бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд “Чацарганын кластерын худалдаа-хамтын ажиллагааны тогтолцоо бүрдүүлэх, өртгийн сүлжээ үүсгэх” зөвлөх үйлчилгээний гэрээг Монголын жимс жимсгэнийн үндэсний холбоотой гэрээ байгуулан чацарганын кластерын тогтолцоо бий болгох, өртгийн сүлжээ үүсгэх ажлыг тариаланчид, боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчидтэй хамтран хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд чацарганын өртгийн сүлжээг хөгжүүлэх үе шат хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан хамтын ажиллагааны тогтолцоо бүрдүүлэх ажлын хэрэгжүүлж байна. Европын холбооны санхүүжилтээр хэрэгжиж буй “Монголын худалдааг дэмжих” TRAM төслийн хүрээнд “Чацарганын кластер байгуулах” төсөл хэрэгжүүлж чацарганын кластерт оролцогчдыг бүртгэлжүүлэн хамтын санамж бичиг байгуулан, удирдах зөвлөлийг сонгож хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргав. 2020 оны 1 дүгээр сард Герман улсад зохиогдсон Green week хүнсний бүтээгдэхүүний олон улсын үзэсгэлэнд тус төслөөс 11.0 мянган еврогийн санхүүжилт зардал гарган стенд түрээсэлж чацаргана боловсруулах 4 үйлдвэрийн бүтээгдэхүүнийг оролцуулж олон улсад сурталчлав.	40%
9	1.9. Жимс, жимсгэнийн кластерийн гол оролцогч болон хамтрагч, тариалагч хооронд үүрэг, хариуцлагыг нарийвчлан хуваарилах, ложистик, тээвэр, банк, санхүүгийн байгууллага, даатгал, боловсрол, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагын оролцоог хангах;	2019 - 2022		Европын холбооны санхүүжилтээр хэрэгжиж буй “Монголын худалдааг дэмжих” TRAM төслийн хүрээнд “Чацарганын кластер байгуулах” төсөл хэрэгжүүлж чацарганын кластерт оролцогчдыг бүртгэлжүүлэн хамтын санамж бичиг байгуулан, удирдах зөвлөлийг сонгож хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргав. Мөн кластерт оролцогчдоор үүрэг хариуцлагын санамж бичигт гарын үсэг зуруулав. Энэхүү төслийн хүрээнд 2019, 2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан удирдах хороогоор хэлэлцүүлж хэрэгжүүлэх ажлыг эхлүүлээд байна. Энэ ажлын хүрээнд Европын холбооны санхүүжүүлэгч байгууллагатай 2 дугаар сард уулзалт хийж хэрэгжүүлэх ажил шаардлагатай санхүүжилтийн талаар хэлэлцсэн ба цаашид хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэхээр харилцан ойлголцсон.	70%

10	1.10. Бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа, худалдааны дэвшилтэт арга, хамтын ажиллагааг хөгжүүлж, тогтвортой нийлүүлэлтийн сүлжээ (Global өртгийн сүлжээ г.м)-г үүсгэх, түүнийг орон нутгийн нөөцөд түшиглэсэн дэд кластер болгон хөгжүүлэх;	2019 - 2022		АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй "Хөдөө аж ахуй хөдөөгийн хөгжил төслийн нэмэлт санхүүжилт" төслийн хүрээнд "Чацарганын бүтээгдэхүүний гадаад зах зээлийн судалгаа" зөвлөх үйлчилгээний ажлыг нээлттэй тендер шалгаруулан Бодлогын шийдэл ТББ-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэн. Энэхүү ажлын хүрээнд Тайвань, Япон, БНСУ-ын чацарганын зах зээлийн судалгааг улс тус бүрээс 5 үйлдвэр нийт 15 үйлдвэр, бөөний худалдаа эрхлэгч 15, жижиглэнгийн худалдаа эрхлэгч 30 компани, нийт 500 гаруй иргэн хэрэглэгчээс судалгаа авч гүйцэтгүүлэн 3 үе шатны тайланг хэлэлцүүлэн хүлээн авсан. Судалгааны ажлаар эмхтгэл гаргаж Монгол улсын чацаргана боловсруулах үйлдвэрүүдэд танилцуулав. Энэхүү ажлын хүрээнд ОХУ, БНХАУ-ын чацарганын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспорт, Монгол улсын чацарганын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өнөөгийн байдал зах зээл, экспорт, импорт түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг салбарын бодлого, эрх зүй, чанар стандарт, тээвэр ложистик институц, технологи, судалгаа, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг хамруулан хийсэн нэн үр өгөөжтэй ажил болсон. 2020 онд Европын холбооны чацарганын бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа хийлгэхээр Европын холбооны Трам төсөлд хүсэлт тавиад байна.	70%
11	1.11. Инноваци, шинэ технологийг хөгжүүлэх, шинэ бүтээгдэхүүн (хөлдөөсөн, хатаасан, нөөшилсөн, нунтаг, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн зэрэг) болон шинэ сорт гаргах, усалгаажуулах, хураах технологийг сайжруулах, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;	2018 - 2022		Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2019 онд Мон-адонис ХХК-ийн "Жимс жимсгэнийн хуурай ханд үйлдвэрлэх" төсөлд 155.4 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгов. Азийн хөгжлийн банкны буй "Хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг дэмжих" техник туслалцааны төслийн "Чацаргана" бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 945.3 сая төгрөгийн өртөг бүхий чацарганын үрийн тосыг орчин үеийн өндөр технологийн нүүрсхүчлийн хийгээр хандлах аргаар ялгаж авах тоног төхөөрөмжийг нийлүүлж ШУТИС-ын Техник, технологийн туршилт судалгааны төв дээр суурилуулан олон улсын стандартад нийцсэн үрийн тосыг гарган авч судлах, олон улсад баталгаажуулах, экспортыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэв. Энэхүү цехийн туршилтын ажлыг эхлүүлж Хаан жимс ХХК-ийн чацарганын үрийг туршилтын журмаар боловсруулан үрийн тос гаргаж дээжийг олон улсад шинжлүүлж байна. Тус яамны захиалгаар "Чацаргана жимсний нитэг, үр, хальсны найрлага, биологийн идэвхт нэгдлийг сортоор тодорхойлох, тэдгээрийг боловсруулах технологи, амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүнд баяжуулагчаар ашиглан эрүүл мэндийг дэмжих үйлдэлтэй хүнсний технологийн шийдэл гаргах" ШУТ-ын төслийг ШУТИС-д 2021 оноос хэрэгжүүлэхээр тус яамнаас шийдвэрлэв.	100%
12	1.12. Жимс, жимсгэнэ тариалдаг иргэн, аж ахуйн нэгжид өртгийн сүлжээний санхүүжилтийн талаар ганиулах, сурталчлах, өөрийн орны онцлогт нийцсэн санхүүгийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх;	2019 - 2022		Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй "Хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг дэмжих" техник туслалцааны төслийн "Чацаргана" бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд "Чацарганын кластерын худалдаа-хамтын ажиллагааны тогтолцоо бүрдүүлэх, өртгийн сүлжээ үүсгэх" зөвлөх үйлчилгээний гэрээг Монголын жимс жимсгэнийн үндэсний холбоотой гэрээ байгуулан чацарганын кластерын тогтолцоо бий болгох, өртгийн	70%

				сүлжээ үүсгэх ажлыг тариаланчид, боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчидтэй хамтран хэрэгжүүлж байна. Энэхүү ажлын хүрээнд 2 удаа уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж өргийн сүлжээний талаар танилцуулж сурталчилсан. Европын холбооны санхүүжилтээр хэрэгжиж буй “Монголын худалдааг дэмжих” TRAM төслийн хүрээнд “Чацарганын кластер байгуулах” төсөл хэрэгжүүлж чацарганын кластерт оролцогч үйлдвэрлэгч, тариалагч, судалгааны байгууллагыг бүртгэлжүүлэн хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан. Энэхүү төслийн хүрээнд Европын сэргээн босголт хөгжлийн банкны төлөөлөлтэй уулзаж санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх талаар хүсэлт гаргаж санал солилцов. Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн хүрээнд “Жимс жимсгэнийн тариалалт ба бүтээгдэхүүн хөгжүүлэлт” зөвлөгөөн, сургалт зохион байгуулан төсөлд хамрагдсан 6 аймаг нийслэлийн 100 гаруй жимс жимсгэнэ тариалагч, боловсруулагчдыг хамруулан мэдлэг чадварыг сайжруулах арга хэмжээ зохион байгуулж, хамтран ажиллах ажлын давуу талыг сурталчлав.	
13	1.13. Жимс, жимсгэнийн тариалалтын талбайг тордон хөрсний үржил шимийг сайжруулах замаар үр өгөөжийг нэмэгдүүлэх, хамгаалалтын ойн зурвас байгуулах, гэр хорооллын өрх хашаанд жимсний мод бут, тэр дундаа чацаргана тариалах иргэдийг дэмжих;	2018 - 2022		<p>Монгол оронд байгаль хамгаалах, цөлжилттэй тэмцэх үйлсэд хувь нэмэр оруулахын төлөө 10 гаруй жил 5 аймаг, УБ хотын СБД-т нийт 668 га-д үйл ажиллагаа явуулж буй БНСУ-ын хөрөнгө оруулалттай “Ногоон Ази-сүлжээ” ТББ-тай сүүлийн 2 жил сургалт, мэдээлэл, зөвлөх үйлчилгээ болон чацаргана, гоёл чимэглэлийн сортын болон чанарын шаардлага хангах суулгац нийлүүлэхэд Монголын жимс жимсгэний үндэсний холбоо хамтран ажиллаж байна.</p> <p>БНСУ-ын хөрөнгө оруулалттай “Ногоон ази” Олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа цөлжилтөөс хамгаалах, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор Аргалант суманд 100 га талбайг хашаажуулан 47400 ш чацаргана тариалж, ойн зурваст 35400 мод тариалсан. Мөн тус төслийн хүрээнд Баянцогт суманд 100 га талбайд ойн зурвас байгуулан 10000 ш чацаргана, ойн зурваст 10000 ш бусад төрлийн мод тариалаад байна. Төв аймгийн хэмжээнд жимс, жимсгэний 335 га талбайд ойн зурвас байгуулж, нийт тариалсан талбайн 39%-ийг хамруулсан байна. Жимс, жимсгэнэ тарьсан талбай бүрэн хашаажуулагдсан байна.</p> <p>Хөрсний үржил шим сайжруулах, ургацын тоо хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор 2019 онд Хөдөө аж ахуйг дэмжих сантай хамтран химийн бодис, бордооны хэрэглээг бууруулах хүрээнд ургалтыг дэмжих байгалийн гаралтай гумины бордоо 100.0 тн, ургамлын өсөлт идэвхжүүлэгч ургамлын гаралтай бэлдмэл 4.8 тн, биологийн бэлдмэл 12.5 тн тус тус нийлүүлэн тариаланчдад хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох ажлыг зохион байгуулсан. Аймаг, орон нутгийн жимс жимсгэнэ тариалагчид бууцыг бордоонд өргөнөөр ашиглаж байгаа бөгөөд цаашид чийгийн улаан хорхойгоор боловсруулсан бордоо болон бусад органик бордооны хэрэглээг дэмжиж байна. Тухайлбал Булган аймгийн</p>	100%

				<p>Сэлэнгэ сумын “Хас тав” ХХК-ийн үйлдвэрлэж буй чийгийн улаан хорхойн бордоог аймгийн санхүүжилтээр 20 өрхөд тараан бууцанд үржүүлэн бордоо гаргахад дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Булган аймагт “Шинэ хөдөө” төсөл хэрэгжүүлж чацаргана болон бусад жимс жимсгэнэ тариалах хөдөлгөөн өрнүүлэн 16 сумын 1 тосгоны 1693 иргэн, 132 бүл, 661 өрхийг хамруулан зохион байгуулж, дэмжлэг үзүүлсэний үр дүнд 2018 онд 174.4 га-д, 2019 онд 68.7 га-д тариалалт хийж аймгийн жимс жимсгэний талбай 715 га-д хүрч, үүний 98.3 хувийг чацарганын тариалалт эзэлж байна.</p> <p>Булган аймгийн Дашинчилэн, Баяннуур суманд хэрэгжиж буй “Ногоон хэрэм” хөтөлбөрийн хүрээнд ойжуулалтын талбай болон Дашинчилэн сумын Эмийн хүрээлэнгийн тариалангийн 68.0 га талбайд хамгаалалтын зурвас байгуулав.</p> <p>Жимс жимсгэнийн талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулах технологийн стандарт боловсруулж 2020 онд стандартын хороогоор хэлэлцүүлэхээр стандартын дэд хорооны төлөвлөгөөнд тусгуулав.</p>	
14	<p>1.14. Кластерийн бүрэлдэхүүн хэсэг бүрт чанарын хяналтын тогтолцоог сайжруулах, GAP, GLOBAL GAP, ISO, HACCP зэрэг олон улсын стандартуудыг нэвтрүүлэх, хураасан жимсний хадгалах, тээвэрлэх (хөргөлттэй агуулах, машин зэрэг), сав, баглаа боодлын нэгдсэн стандартыг батлан мөрдүүлэх;</p>	2019 - 2021		<p>“Чацаргана боловсруулах үйлдвэрүүдэд хүнсний чанар аюулгүй байдлын олон улсын стандартыг нэвтрүүлэх” зөвлөх үйлчилгээний гэрээг Обзерв стар ХХК-тай байгуулан төсөлд оролцсон чацаргана боловсруулах 8 үйлдвэрт олон улсын чанарын удирдлагын тогтолцооны талаар цогц сургалтуудыг 2019 онд шат дараатай явуулж тус сургалтад идэвхтэй оролцож дотоодын баталгаажуулалтаар хангалттай үнэлгээ авсан “Еден” ХХК, “Увс Хүнс” ХК-д 2020 оны 2 сард олон улсын баталгаажуулалтын байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэн ISO 9001 чанарын удирдлагын тогтолцооны гэрчилгээ авах шаардлага хангуулав. Үүний үр дүнд чацарганын бүтээгдэхүүний чанар сайжрах, олон улсын стандарт нэвтрүүлэх нөхцөл 2 үйлдвэрт бүрдэв. Нийт 21 аймаг, Нийслэлд сав баглаа боодлын дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, тайлагнан ажиллаж байна. Нийслэлийн 9 дүүрэгт “Хуванцар савны хэрэглээ, түүний хор хөнөөл” сэдэвт сургалтыг 18 удаа хийж, нийт 2010 иргэн, аж ахуйн нэгж байгууллага хамрагдсан. Европын холбооны хүнстэй харьцах материалын аюулгүй байдлын 3 стандарт, Олон улсын стандартчиллын байгууллагын үйлдвэрлэлийн зохистой дадлын 1 стандартыг Монгол улсад нутагшуулах зөвшөөрөл авч, ISO/TS 22002-4:2013 Хүнсний аюулгүй байдлыг хангах угтвар нөхцөл-4-р хэсэг, Хүнсний сав баглаа боодлын үйлдвэрлэл /Prerequisite programmes on food safety -- Part 4: Food packaging manufacturing/ Үндэсний стандартын төсөл, EN 1186-1:2002 (WI=00194065), Хүнсний бүтээгдэхүүнтэй харьцдаг материал ба хэрэглэгдэхүүн-Хуванцар-Хэсэг1. Нийт шилжилтийн нөхцөл болон сорилын аргыг сонгоход баримтлах заавар /Materials and articles in contact with foodstuffs - Plastics - Part 1: Guide to the selection of conditions and test methods for overall migration/ Үндэсний стандартын төсөл, EN 1186-3:2002 (WI=00194067), Хүнсний бүтээгдэхүүнтэй харьцдаг материал ба</p>	70%

				хэрэглэгдэхүүн-Хуванцар-Хэсэг3. Зэрэг Үндэсний стандартын төслийг тус тус боловсруулан, СХЗГ-ын Хүнсний стандартчиллын Техникийн хороонд хүргүүлсэн.	
15	1.15. Монгол чацаргана бүтээгдэхүүний стандартыг тогтоох, түүнийг олон улсад баталгаажуулах, чацарганыг органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, брэнд болгон хөгжүүлэх;	2019 - 2021		2018 онд БНСУ-ын АФАСИ олон улсын байгууллагаас хэрэгжүүлсэн “Органик тариалан” төслийн хүрээнд Ургамал хамгааллын хүрээлэнтэй гэрээ байгуулан органик чацаргана ургуулах технологи боловсруулах зорилгоор чацарганын талбайд байгаа хөнөөлт өвчин, хортны тархалтыг судлах, тэдгээртэй химийн бус аргаар тэмцэх, органик бордоо үйлдвэрлэж турших судалгаа хийлгэж, органик тариалалтын мэдлэг олгох сургалтыг Улаанбаатар хотод зохион байгуулж 53 хүн хамруулсан ба, “Органик чацарганын цэцэрлэг” гарын авлага 500 ширхэгийг хэвлүүлж түгээв. 2019 онд Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй “Хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг дэмжих” техник туслалцааны төслийн “Чацаргана” бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд БНХАУ-д үйлдвэрлэсэн шавьж баригч наалтын цехийг нийлүүлж Ургамал хамгааллын хүрээлэнд суурилуулав. 2019 онд цехийн үйл ажиллагааг эхлүүлэн туршилтын журмаар 1000 ширхэг наадаг цаас үйлдвэрлэн органик жимс жимсгэнийн тариалалтын технологи боловсруулах туршилт судалгааны ажлыг эхлүүлэв. 2020 онд 96 сая төгрөгийн санхүүжилтээр 10.0 мянган ширхэг цаас үйлдвэрлэх 3.0 тонн түүхий эд, материалыг төслийн санхүүжилтээр нийлүүлэхээр шийдвэрлэж тендер зарласан ба цаашид борлуулалтын орлогоос үйл ажиллагааны зардлыг нөхөн тогтвортой ажиллах, чачарганы органик тариалан хөгжих боломж бүрдэв. АХБ-ны төслийн санхүүжилтээр Увс, Төв аймагт чацарганын тариаланд ХАА-н зохистой дадал нэвтрүүлэх, талбайд хавар, зуны улиралд хийх агротехникийн арга ажиллагааны сургалт зохион байгуулж нийт 138 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулав.	40%
16	1.16. Хүнсний аюулгүй байдалд нийцсэн жимс, жимсгэнийн бүтээгдэхүүний сав, баглаа боодол, шошгын стандартыг олон улсын стандартад нийцүүлэн батлах, мөрдүүлэх.	2019 - 2020		Европын холбооны хүнстэй харьцах материалын аюулгүй байдлын 3 стандарт, Олон улсын стандартчиллын байгууллагын үйлдвэрлэлийн зохистой дадлын 1 стандартыг Монгол улсад нутагшуулах зөвшөөрөл авч, ISO/TS 22002-4:2013 Хүнсний аюулгүй байдлыг хангах угтвар нөхцөл-4-р хэсэг, Хүнсний сав баглаа боодлын үйлдвэрлэл /Prerequisite programmes on food safety -- Part 4: Food packaging manufacturing/ Үндэсний стандартын төсөл, EN 1186-1:2002 (WI=00194065), Хүнсний бүтээгдэхүүнтэй харьцдаг материал ба хэрэглэгдэхүүн-Хуванцар-Хэсэг1. Нийт шилжилтийн нөхцөл болон сорилын аргыг сонгоход баримтлах заавар /Materials and articles in contact with foodstuffs - Plastics - Part 1: Guide to the selection of conditions and test methods for overall migration/ Үндэсний стандартын төсөл, EN 1186-3:2002 (WI=00194067), Хүнсний бүтээгдэхүүнтэй харьцдаг материал ба хэрэглэгдэхүүн-Хуванцар-Хэсэг3. Хүнсийг орлуулах загвар орчинд бүрэн ачлж, нийт шилжилтийг тодорхойлох сорилын аргууд /Materials and articles in contact with foodstuffs	70%

					- Plastics - Part 3: Test methods for overall migration into aqueous food simulants by total immersion/ Үндэсний стандартын төсөл, EN 1186-9:2002 (WI=00194073) Үндэсний стандартын төслийг тус тус боловруулан, СХЗГ-ын Хүнсний стандартчиллын Техникийн хороонд хүргүүлсэн. “Хүнсний зориулалтын хуванцар материалын аюулгүй байдлын техникийн зохицуулалт”-ын төслийн хамрах хүрээ, үндсэн бүтцийг тодорхойлсон. Санал авахаар сав баглаа боодлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, үйлдвэрлэгчдэд хүргүүлсэн. Нийт 21 аймаг, Нийслэлд сав баглаа боодлын дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, тайлагнан ажиллаж байна. GIZ-ийн ЭТИС төслөөс Увс аймгийн сав баглаа боодлын үйлдвэрлэлд 52,8 сая төгрөгийн буцалтгүй тусламжийг үзүүлсэн. 7. Францын хүнсний тусламжийн сангаас чацаргана үйлдвэрлэгч 4 иргэнд сав баглаа боодлоо сайжруулахад нь зориулж 2 жилийн хугацаатай, хүүгүй, 100 сая төгрөгийн зээл олгосон.	
Зорилт-1-ийн дундаж үнэлгээ					70.0%	
2. Жимс, жимсгэнийн таримлын сорт шалгаруулах, анхдагч үржүүлэг, бойжуулга, суулгац үйлдвэрлэлийг бүсчлэн хөгжүүлж, ган, хүйтэн болон өвчин хортонд тэсвэртэй, нутагшсан сортын суулгацын хангамжийг нэмэгдүүлэх;						
17	2.1. Бүсийн эрдэм шинжилгээний байгууллагууд, томоохон аж ахуйн нэгжүүдийг түшиглэн жимс, жимсгэнийн төрөл, зүйлийн сорт нутагшуулах, анхдагч үржүүлэг, бойжуулга, суулгац үйлдвэрлэлийн ажлыг эрчимтэй явуулах;	2018 - 2022	1,200.0		Нэгдсэн үндэсний байгууллагын хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын санхүүжилтээр “Монгол улсын жимс жимсгэнийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх” ТСП/MON/3605 төслийг хэрэгжүүлж алим, чавга, интоор, гүзээлзгэнэ, үхрийн нүд, далан хальс зэрэг яст, үрт 6 төрлийн 21 сортын 2450 ширхэг суулгацыг ОХУ-ын Горный-Алтай жимс жимсгэнийн станцтай гэрээ байгуулан 2018 оны 5 сард хүлээн авч Дархан-уул аймаг дахь Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн судалгааны талбайд тариалан Монгол улсад нутагшуулах туршилт судалгааны ажил эхлүүлэв. Тус төслийн хүрээнд Дархан-уул аймагт жимс жимсгэнийн таримлын гадаад хорио цээрийн хяналт тогтоох 400 м2 талбай бүхий өвлийн хүлэмжийг байгуулж ажиллуулж эхэлсэн. Улсын төсвийн 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Ховд аймгийн Булган, Жаргалант суманд жимс жимсгэнийн суулгац үржүүлгийн төвийг анх удаа байгуулав. Энэхүү ажлын хүрээнд Булган суманд 3.2 км усалтын систем байгуулан 1500 ширхэг жимс жимсгэнийн мод тариалж суулгац үржүүлгийн эх цэцэрлэг байгуулан, 1000 ширхэг бургасаар ойн зурвас байгуулав. Жаргалант суманд 10 га талбайд бетонон суурьтай төмөр торон хашаа, сургалтын байр, 2 ширхэг нарлаг хүлэмж байгуулж, 1 иж бүрдэл трактор, хөргүүртэй контейнер нийлүүлсэн ба цахилгаан, усалтын системийн толгойн барилга, усалгааны сувгийн ажлыг гүйцэтгэж 2020 онд суулгац үржүүлгийн эх цэцэрлэг байгуулах бэлтгэл хангагдав. Өмнөговь аймаг Дархан-Уул аймгийн УГТХүрээлэн, ХААИС-тай хамтран жимс, жимсгэнийн туршилтын талбайг бий болгон 130 ширхэг жимсний модны суулгацыг тарьж эх цэцэрлэг байгуулан эрдэм шинжилгээ, туршилт, судалгааны ажлууд хийгдэж эхлэв.	100%
18	2.2. Алим, чавга, интоор, чацаргана, үхрийн нүд, нэрс, гүзээлзгэнэ, бөөрөлзгөнө,	2019 - 2022	20.0		Хөтөлбөрийн хүрээнд 2018 онд улсын төсвийн 785.6 сая төгрөгийн санхүүжилтээр нийт 165500 ширхэг чацаргана, 33000 ширхэг	100%

	<p>хад зэрэг жимс, жимсгэнийн сортын суулгацын ил талбайн болон хүлэмжийн эх цэцэрлэг, үржүүлгийн загвар аж ахуй байгуулахад дэмжлэг үзүүлэх, гэдгээрийн бэлтгэсэн суулгацыг худалдан авч, жимс, жимсгэнэ тариалах иргэн, аж ахуйн нэгжид годорхой хувийн хөнгөлөлттэй үнээр болон урт хугацаатай зээлээр олгох;</p>			<p>үхэр нүд, 6900 ширхэг алим, 5750 ширхэг чавганы суулгацыг гадаад, дотоодын үйлдвэрлэгчдээс тендер шалгаруулан нийлүүлж 18 аймаг, нийслэлийн 150 гаруй иргэн, аж ахуйн нэгжид 10 хувийн урьдчилгаатай, 6 жилийн хугацаатай хүүгүй зээлээр олгож тариалуулан жимст цэцэрлэгийн талбайг 166 га талбайгаар нэмэгдүүлэв. Говь-алтай аймгийн иргэн Мянганцэцэгт үржүүлгийн аж ахуй байгуулахад зориулан ЖДҮДСангаас 20.0 сая төгрөгийн зээл олгов. 2020 онд Сүхбаатар, Говь-Алтай аймагт суулац үржүүлгийн төв байгуулахаар улсын төсөвт суулгасан ба энэ онд Аймгийн ХХААГ-тай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Төв аймгийн “Поливит” ХХК ОХУ-ын “Минусинский Эрдэм шинжилгээний хүрээлэн”-ээс Монгол оронд ургах боломжтой алим, интоор, чавга, бөөрөлзгөнө, далан хальс зэрэг 11 нэр төрлийн 20 сортын жимсний суулгацыг эх цэцэрлэгтээ тарьж үржүүлэг хийгдэж байна. 2020 оноос эхний суулгацыг залгалт хийхээр болоод байна. Мөн Батсүмбэр сумын “Үдлэг эх” ХХК ОХУ-ын Иркутскийн Улсын их сургуулийн Ботаникийн цэцэрлэгтэй танилцан туршлага судалж, алимны 3, чавганы 3 сортын суулгацыг авчирч тариалж нутагшуулах, үржүүлэх ажлууд хийгдэж байна. Булган аймгийн Сэлэнгэ сумын “Ингэт чацаргана” ХХК, Бугат сумын “Солар рэйн” ХХК-иуд жилдээ 20.0 мянган ширхэг суулгац үржүүлэн гаргаж, нөхөн тариалалтандаа ашиглахаас гадна зах зээлд нийлүүлж байна. Мөн суулгац үржүүлэх болон хамгаалагдсан хөрсний тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор “Шинэ хөдөө Булган” төслийн санхүүжилтээр 16 1 сум 1 тосгоны 101 иргэнд хөнгөлөлттэй, урт хугацааны зээлээр хүлэмж олгосон байна.</p>	
19	<p>2.3. Жимс, жимсгэнийн суулгац үржүүлэх дэвшилтэт технологийг нэвтрүүлж, ургац, чанарыг дээшлүүлэх, тарьц, суулгацыг шинжлэх ухааны үндэслэлтэй үржүүлэх, дэвшилтэт технологийг боловсруулах, агроэкологийн бүсүүдэд нэвтрүүлэх;</p>	2018 - 2022		<p>2019 онд улсын төсвийн 147.4 сая төгрөгийн улсын төсвийн санхүүжилтээр суулгац үржүүлэх дэвшилтэт технологийн мананжуулагч бүхий 120 м2 талбай бүхий 10 иж бүрдэл нийлэг хальсан хүлэмж нийлүүлж ХХААХУ-ийн Сайдын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А-78 дугаар тушаал гарган суулгац үржүүлэх иргэн аж ахуйн нэгжид 30 хувийн урьдчилгаатай 4 жилийн хүүгүй зээлээр олгож эхлэв. Үүний үр дүнд суулгац үйлдвэрлэл 200.0 мянган ширхэгээр нэмэгдэх боломж бүрдүүлэв. Өмнөговь аймаг Дархан-Уул аймгийн УГТХүрээлэн, ХААИС-тай хамтран жимс, жимсгэнийн туршилтын талбайг бий болгон 130 ширхэг жимсний модны суулгацыг тарьж эх цэцэрлэг байгуулан эрдэм шинжилгээ, туршилт, судалгааны ажлууд хийгдэж эхлэв. Өвөрхангай аймгийн Хархорин сумын “Хархорин” ХХК чацаргана, гүзээлзгэнэ, бөөрөлзгөнө зэрэг жимсний суулгацыг шинжлэх ухааны үндэслэлтэй дэвшилтэт технологиор батлагдсан стандартын дагуу үйлдвэрлэж, 2019 оны хаврын тариалалтаар чацарганы 80000ш, үхрийн нүдний 5000ш, гүзээлзгэний 1000ш, бөөрөлзгөний 1000ш, нийт 87000ш суулгацыг өөрийн аймгийн болон бусад аймгийн тариаланчдад нийлүүлж суулгацын дотоодын эрэлтийг хангахад томоохон хувь нэмэр оруулж байна.</p>	100%

					Төв аймгийн Батсүмбэр сумын “Поливит” ХХК, “Үдлэг эх” ХХК, Баянчандмань сумын “Дахашим” ХХК, Лүн сумын “Ногоон хэрэм” төсөл, Эрдэнэ сумын “Манлай уургач” ХХК зэрэг ААН-үүд чацарганы 114670 ш, үхрийн нүдний 17680 ш, интоорын 5500 ш ш, бөөрөлзгөний 5200 ш, бусад жимсний 13300 ш суулгацын үржүүлэг хийж, нийт 8 нэр төрлийн 156350 ш чанарын шаардлага хангасан суулгацыг дотоодын зах зээлд нийлүүлсэн байна.	
20	2.4. Байгалийн жимс, жимсгэнийн нэр төрөл, тархалт, нөөц, генетикийн судалгааг үе шаттай явуулах, тэдгээрийн генетик нөөц, селекцийн эх материалд тулгуурлан өөрийн орны байгаль, цаг уурын нөхцөлд зохицсон сорт, дээжүүдийг турших.	2022			Хугацаа болоогүй	Үнэлэх боломжгүй
Зорилт-2-ын дундаж үнэлгээ						100.0%
3. Жимс, жимсгэнийн тариалалт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг инноваци, дэвшилтэт техник, технологи, шинжлэх ухааны судалгаанд суурилуулан цогц байдлаар хөгжүүлэх, салбарын хүний нөөцийг чадавхжуулах;						
21	3.1. Орчин үеийн технологид суурилсан хамгаалагдсан хөрсний аж ахуйг хөгжүүлж, дулаан нөхцөл шаарддаг усан үзэм, тоор, лийр, нимбэг, гүзээлзгэнэ, анар, улаан чавга зэрэг жимс, жимсгэнийг нутагшуулах, тариалалтыг нэмэгдүүлэх;	2019 - 2022	2,400.0		Хүлэмжийн жимс жимсгэнийн тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газрын 2018 оны 324 дүгээр тогтоол гарган жил бүрийн 11 дүгээр сарын 1-нээс 5 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд өвлийн хүлэмжийн цахилгааны хэрэглээнд 100 хувь хөнгөлөлт үзүүлэхээр шийдвэрлүүлсэн. Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэхээр 2020 онд улсын төсөвт 2.4 тэрбум төгрөгийн санхүүжилт тусгуулсан ба 19 аймаг, нийслэлийн 137 хүлэмжийн аж ахуй эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийн судалгааг гарган Эрчим хүчний яаманд хүргүүлж хөнгөлөлтийг 2020 оны 01 сараас тооцож эхлэв. Үүний үр дүнд өвлийн хүлэмжийн аж ахуй хөгжих нөхцөл бүрдэв. Сүүлийн жилүүдэд хүлэмжийн жимсний тариалалт эрхлэх эхлэл санаачилга идэвхжиж байна. Тухайлбал Төв аймгийн Борнуур сумын “Эко урьхан” ХХК, Баянхангай сумын Багжакс ХХК БНХАУ-аас усан үзмийн 15060 ш суулгац импортолж тариалсан бол Төв аймгийн Атрын шим ХХК усан үзмийн 50 кг ургац хурааж авав 2019 оны 5,6,7 сард БНСУ-ын Гангвон аймаг, ХААИС-тай хамтран Төв аймгийн бүх сумдын 230 гаруй хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийг хамруулсан “Хүлэмжийн эрчимжсэн технологи” 4 удаагийн сургалт зохион байгуулав. Сургалтаар хүлэмжинд гүзээлзгэнэ тариалах арга технологийн мэдлэг чадвар олгов. Тус яамны санхүүжилтээр “Хүлэмжинд жимс жимсгэнэ тариалах технологи” сургалтыг Монголын хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн холбоо ТББ-тай гэрээ байгуулан 2018 онд Улаанбаатар хот, Сэлэнгэ аймагт сургалт зохион байгуулж 300 хүн хамруулж мэдлэг чадвар олгов.	100%
22	3.2. Байгалийн жимс, жимсгэнийн тарималжуулан үйлдвэрлэлийн нөөц бий болгож, үйлдвэрлэлд нийлүүлэх;	2020			Хугацаа болоогүй	Үнэлэх боломжгүй
23	3.3. Жимс, жимсгэнийн тариалалт, хураалт, хадгалалтын технологийг хөрс, бордоо, ургамал	2018 - 2022			Тус яамны захиалгаар улсын төсвийн 120 сая төгрөгийн санхүүжилтээр “Жимсний селекцийн судалгаа, ирээдүйтэй сортын суулгац үржүүлэг” ШУТ-ийн төслийг Дархан-	100%

	хамгаалал, сортын суулгац үржүүлэг, усжуулалт, механикжуулалт, хадгалалт, гээвэрлэлт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг цогцоор нь боловсруулах;			уул аймаг дахь Ургамал газар тариалангийн хүрээлэнд 2 дахь жилдээ хэрэгжүүлэв. Төслийн хүрээнд Монгол орны хөрс цаг уурын нөхцөлд зохицсон байгалийн жимс жимсгэнийн дээж хэлбэрүүдэд сонголт хийж, хүссэн шинж тэмдэг бүхий шинэ хэлбэрүүдийг шалгаруулах шинэ сорт гаргах бэлтгэл хангах, нутагшсан сорт шалгаруулах, баталгаажсан сортын суулгац үржүүлэх ажлыг бүсчлэн хөгжүүлж, зах зээлд нийлүүлэх ажлыг гүйцэтгэж байгаа ба жимс жимсгэнийн 0.5 га генофондын талбай шинээр байгуулав. Энэ талбарт алим, чавга, интоор, лийр, ирга, үхэр нүд, гүзээлзгэнэ, далан хальс, улаалзгана зэрэг 9 төрлийн жимс жимсгэнийн 23 сортын 596 ширхэг мод, бут, байгалийн чацарганын 23 хэлбэрийн үр суулгац тариалж нарийвчилсан судалгаа явуулж байна. Мөн 7 төрлийн жимс жимсгэнийн 5877 ширхэг нутагшсан сортын суулгацыг үржүүлж зах зээлд нийлүүлээд байна. Нэгдсэн үндэсний байгууллагын хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын санхүүжилтээр хэрэгжсэн “Монгол улсын жимс жимсгэнийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх” ТСП/MON/3605 төслийн хүрээнд Монголын жимс жимсгэнийн үндэсний холбоогоор “Монгол орны мезо уур амьсгалын зураглал ба жимс жимсгэнэ тариалах тохиромжийн зэрэглэл” судалгааны ажлыг гүйцэтгүүлэв. Энэхүү ажлын хүрээнд Монгол орны хэмжээнд жимс жимсгэнэ тариалах боломжтой газар нутгийг тохиромжийн зэрэглэлийг тодорхойлж гаргаснаар жимс жимсгэнэ шинээр тариалах сонирхолтой байгаа иргэд, аж ахуйн нэгжид тариалах талбайгаа эрсдэл багатай сонгоход ихээхэн ач холбогдолтой томоохон судалгааны ажил болов. Судалгааг 300 хувь хэвлүүлж жимс жимсгэнэ тариалагчдад олгов.	
24	3.4. Чацарганыг хатаах, хөлдөөх, хуурайшуулах, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэх, тосыг нь чанарын өндөр түвшинд боловсруулах, чацарганын жимс, навч, мөчир, холтсыг бүтээгдэхүүний үйлдвэрлэлд ашиглах туршилт явуулах, дэвшилтэт технологи нутагшуулах, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи турших, үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх;	2018 - 2022	430.4	Азийн хөгжлийн банкны хэрэгжүүлж буй “Хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг дэмжих” техник туслалцааны төслийн “Чацаргана” бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 945.3 сая төгрөгийн өртөг бүхий чацарганын үрийн тосыг орчин үеийн өндөр технологийн нүүрсхүчлийн хийгээр хандлах аргаар ялгаж авах тоног төхөөрөмжийг нийлүүлж ШУТИС-ын Техник, технологийн туршилт судалгааны төв дээр суурилуулан олон улсын стандартад нийцсэн үрийн тосыг гарган авч судлах, олон улсад баталгаажуулах, экспортыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэв. Энэхүү цехийн туршилтын ажлыг эхлүүлж Хаан жимс ХХК-ийн чацарганын үрийг туршилтын журмаар боловсруулан үрийн тос гаргаж дээжийг олон улсад шинжлүүлж байна. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2019 онд Мон-адонис ХХК-ийн “Жимс жимсгэнийн хуурай ханд үйлдвэрлэх” төсөлд 155.4 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгов. Улаанбаатар хотод БНСУ-ын хөрөнгө оруулалт, санхүүжилттэй “Ногоон Ази-сүлжээ” ТББ жилд 600 тонн чацаргана боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэв. Өмнөговь аймгийн Даланзадгад сумын "Их говийн төгөл" ХХК-д орон нутгийн жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас 275.0 сая төгрөгийн зээл олгож жилд 40 тн шүүс ундаа, 100 литр чацарганын тос	100%

				үйлдвэрлэх хүчин чадалтай "Чацаргана боловсруулах" цех ашиглалтанд оруулав.	
25	3.5. Монгол чацарганын (таримал болон байгалийн) биохими, генетик, бүтээгдэхүүний шинж чанар, хүнсний хангамж, эрүүл мэнд, гоо сайхан зэрэгт үзүүлэх нөлөөллийн нарийвчилсан судалгааг хөгжүүлж, онцлог шинж чанарыг нь тогтоон олон улсын түвшинд баталгаажуулах;	2018 - 2022		"Чацаргана, түүний гаралтай бүтээгдэхүүний биохимийн найрлага ба эмчилгээ, хүнс тэжээлийн шинж чанарын харьцуулсан судалгаа"-ны гэрээг Хими, хими технологийн хүрээлэнтэй байгуулан манай оронд нутагшсан чацарганын сортуудын 6 дээж, Завхан, Ховд, Увс аймгийн 6 сумдын байгалийн чацарганын нутгийн хэлбэрүүдийн 8 популяцаас нутгийн 7 газраас нийт 21 хэлбэрийн дээжийг 9 сарын 12-наас 23-ны хооронд түүж судалгаанд хамруулаад байна. Мөн бүтээгдэхүүний чанарын судалгаанд "Хаан Жимс Эс Би Ти", "Ю-Эф-Си Трейд", "ЕДЕН", "Увс хүнс" зэрэг ХХК-ийн бүтээгдэхүүнүүдийг "Емарт", "Номин их дэлгүүр"-ээс худалдан авч судалгаанд хамруулж байна. Чацаргана жимсний нитэг, үр, хальсны найрлага, биологийн идэвхт нэгдлийг сортоор тодорхойлох, тэдгээрийг боловсруулах технологи, амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүнд баяжуулагчаар ашиглан эрүүл мэндийг дэмжих үйлдэлтэй хүнсний технологийн шийдэл гаргах ШУТ-ын төслийг ШУТИС-д 2021 оноос хэрэгжүүлэхээр тус яамнаас шийдвэрлэв.	100%
26	3.6. Жимс, жимсгэнийн үйлдвэрлэлд хүнсний чанар, аюулгүй байдлыг хангах бодлогын хүрээнд түүхий эд, бүтээгдэхүүнд хүнсний пестицидийн үлдэгдэл, хувиргасан амьд организмыг хянах лабораторийн болон хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх;	2022		Хугацаа болоогүй	Үнэлэх боломжгүй
27	3.7. Жимс, жимсгэнийн талбайд хамгаалах ойн зурвасыг байгуулж, тариалах агротехнологийг боловсруулах, тэдгээрийг хэвшүүлэх;	2018 - 2022		Жимс жимсгэнийн талбайд ойн зурвас байгуулах стандартын төсөл боловсруулав. Стандарт боловсруулж батлуулах ажлын хэсгийг ХХААХҮ-ийн Сайдын тушаалаар байгуулж, 2020 онд стандартын хороогоор хэлэлцүүлэх төлөвлөгөөнд оруулсан ба батлуулахаар ажиллаж байна. БНСУ-ын хөрөнгө оруулалттай "Ногоон ази" Олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа цөлжилтөөс хамгаалах, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор төслийн санхүүжилтээр Аргалант суманд 100 га талбайг хашаажуулан 47400 ш чацаргана тариалж, ойн зурваст 35400 мод тариалсан. Мөн тус төслийн хүрээнд Баянцогт суманд 100 га талбайд ойн зурвас байгуулан 10000 ш чацаргана, ойн зурваст 10000 ш бусад төрлийн мод тариалаад байна. Төв аймгийн хэмжээнд жимс, жимсгэний 335 га талбайд ойн зурвас байгуулж, нийт тариалсан талбайн 39%-ийг хамруулсан байна. Жимс, жимсгэнэ тарьсан талбай бүрэн хашаажуулагдсан байна.	70 %
28	3.8. Өөрийн орны онцлогт гохирсон жимс, жимсгэнийн талбай, хүлэмжид усны зарцуулалт багатай усалгааны дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, хураалтыг механикжуулах;	2018 - 2022	239.2	2019 онд улсын төсвийн 147.4 сая төгрөгийн санхүүжилтээр суулгац үржүүлэх орчин үеийн дэвшилтэт мананжуулах төхөөрөмж бүхий 10 иж бүрдэл суулгац үржүүлгийн хүлэмж, хүнсний ногоо тариалах 120 м2 талбай бүхий орчин үеийн дэвшилтэт дуслын усалгааны төхөөрөмж бүхий 28 иж бүрдэл нийлэг хальсан хүлэмж нийлүүлж ХХААХҮ-ийн Сайдын 2020 оны 03 сарын 18 А-78 дугаар тушаалаар иргэн аж ахуйн нэгжид 30 хувийн	70%

				урьдчилгаа төлбөргүй, 4 жилийн хүүгүй зээлээр олгож байна. Үүний үр дүнд суулгац үйлдвэрлэл жилд 200.0 мянган ширхэгээр, хүнсний нарийн ногооны үйлдвэрлэл 30.0 тонноор нэмэгдэх боломж бүрдэв. Улсын төсвийн санхүүжилтээр Булган аймагт “Шинэ хөдөө” төсөл хэрэгжүүлж 2018 онд 80 га талбай услах жимс жимсгэнийн дуслын усалгааны төхөөрөмж 8 иж бүрдлийг нийлүүлж сумдад суурилуулсан. Булган аймагт хэрэгжүүлж буй Шинэ хөдөө төслийн хүрээнд 2019 онд 239.2 сая төгрөгийн санхүүжилтээр 7 суманд тус бүр 10 га талбай бүхий нийт 70 га талбайд жимс жимсгэнийн дуслын усалгааны төхөөрөмж нийлүүлж суурилуулав. Тус төслийн хүрээнд сүүлийн 2 жилд 8 суманд жимст цэцэрлэгийн талбай байгуулан нийт 50 мянган ширхэг чацаргана, 15.0 мянган ширхэг үхэр нүдний суулгац зээлээр олгон тариалуулж 11 сумын 150 га чацарганын талбайд орчин үеийн дэвшилтэт дуслын усалгааны систем суурилуулж усалгаажуулав.	
29	3.9. Салбарын хүний нөөцийн хэрэгцээг судалж, хэтийн бодлогоотой уялдсан төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;	2019 - 2021		Жимс жимсгэнэ, хүнсний ногоо тариалагчдын улсын анхдугаар зөвлөгөөнийг Улаанбаатар хотод 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулав. Зөвлөгөөнд 22 аймаг, нийслэлийн 400 гаруй ногоочид жимсжид оролцож жимс жимсгэнийн талаар төрөөс баримтлах бодлого чиглэл, хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаар санал бодлоо солилцож цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулав. 2019 оны 10 дугаар сарын 24 –ны өдөр Монголын жимс жимсгэнийн холбоо, ХААИС-тай хамтран “Атар-60 –Жимс жимсгэнэ судлал” эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулав. Бага хуралд 60 гаруй эрдэмтэн судлаач оролцож 20 гаруй судлаачийн эрдэм шинжилгээний ажлаар илтгэл тавигдаж хэлэлцүүлсэн ба эмхтгэлийг ХАА-н шинжлэх ухааны академийн сэтгүүлийн тусгай дугаар ном болгон 300 хувь хэвлүүлж нийтэд түгээв. Нэгдсэн үндэсний байгууллагын хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын санхүүжилтээр хэрэгжсэн “Монгол улсын жимс жимсгэнийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх” ТСР/MON/3605 төслийн хүрээнд Монголын жимс жимсгэнийн үндэсний холбоогоор “Монголын жимс жимсгэнийн салбарын стратегийн бодлогын баримт бичиг”-ийн төсөл, “Мезо уур амьсгалын зураглал ба тохиромжийн зэрэглэл” судалгааны ажлыг гүйцэтгүүлэв. Төслийн хаалтын семинарыг 9 сарын 18-ны өдөр ХХААХҮЯ-нд зохион байгуулав. Монголын жимс жимсгэнийн үндэсний холбоотой гэрээ байгуулан санхүүгийн дэмжлэг үзүүлж “Жимс жимсгэнийн талбайн түүхийн дэвтэр”, “Жимс жимсгэнийн тариалалт, боловсруулалт” гарын авлагыг шинэчлэн боловсруулж тус бүр 1000 хувь хэвлүүлж түгээв.	70%
30	3.10. Чацаргана, жимс, жимсгэнийн чиглэлээр ажиллаж байгаа судлаач, мэргэжилтэн, аж ахуй, үйлдвэрлэл эрхлэгч, сонирхогчдыг дэмжин дотоод, гадаадын мэргэжлийн сургалт,	2018 - 2022		ОХУ-ын Алтай бүсийн жимс жимсгэнийн туршилт судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 1 мэргэжилтнийг урьж ажиллуулан Увс, Ховд, Баян-өлгий, Говь-алтай, Төв, Сэлэнгэ зэрэг 11 аймгийн 20 сумдын жимс жимсгэнэ тариалагчдын талбайд жимс тариалах, суулгац үржүүлэх заавар зөвлөмж өгч мэргэжлийн ур чадварыг	70%

	туршлага судлах арга хэмжээнд өргөн хамруулах, харилцан туршлага солилцох, тэдгээрийн хамтын ажиллагааг хөгжүүлэх;			сайжруулсан нь ихээхэн үр дүнгээ өгөв. Нэгдсэн үндэсний байгууллагын хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын санхүүжилтээр хэрэгжсэн “Монгол улсын жимс жимсгэнийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх” ТСП/MON/3605 төслийн хүрээнд Монголын жимс жимсгэнийн үндэсний холбоогоор “Монголын жимс жимсгэнийн салбарын стратегийн бодлогын баримт бичиг”-ийн төсөл, “Мезо уур амьсгалын зураглал ба тохиромжийн зэрэглэл” судалгааны ажлыг гүйцэтгүүлэв. Төслийн хаалтын семинарыг 9 сарын 18-ны өдөр ХХААХҮЯ-нд зохион байгуулав.	
31	3.11. Байгаль цаг уурын нөхцөл ойролцоо хөрш орны жимс, жимсгэнийн судалгаа, шинжилгээ, үйлдвэрлэл эрхэлж байгаа байгууллага, аж ахуйн нэгж болон салбарын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч олон улсын байгууллагатай холбоо тогтоох, хамтын ажиллагааг өргөжүүлэх;	2018 - 2022		2019 онд чацаргана, жимс жимсгэнийн салбарын үр дүнтэй хамтын ажиллагаа, харилцаа холбоо, мэдээллийн солилцоог бий болгох зорилгоор энэ чиглэлээр ажиллаж байгаа олон улсын байгууллагууд, судалгааны байгууллагууд, төрийн бус байгууллагууд, үйлдвэрлэгчид, боловсруулагчид, зөвлөх компаниуд, тариалагчдын төлөөлөл нийт 33 оролцогч оролцсон уулзалтыг 2019 оны 2-р сард зохион байгуулж хамтын ажиллагаагаа цаашид уялдуулан ажиллахаар тохиролцов. 2019 оны 10 дугаар сарын 24 –ны өдөр Монголын жимс жимсгэнийн холбоо, ХААИС-тай хамтран “Атар-60 –Жимс жимсгэнэ судлал” эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулав. Бага хуралд 60 гаруй эрдэмтэн судлаач оролцож 20 гаруй судлаачийн эрдэм шинжилгээний ажлаар илтгэл тавигдаж хэлэлцүүлэн харилцан мэдээлэл, туршлага солилцсон ба эмхтгэлийг ХАА-н шинжлэх ухааны академийн сэтгүүлийн тусгай дугаар ном болгон 300 хувь хэвлүүлж нийтэд түгээв. 2018 оны 8 дугаар сард Турк улсын Станбул хотод зохион байгуулагдсан Олон улсын хүнсний ногоо, жимс жимсгэнийн таримлын нийгэмлэгийн ХХХ хуралд Монгол улсаас анх удаа 3 төлөөлөгч оролцож жимс жимсгэнийн судалгааны ажлаар мэдээлэл тавьж, туршлага солилцон, олон улсын мэргэжлийн байгууллага, судлаачидтай холбоо тогтоов. НҮБ-ын "Жимс жимсгэнэний үйлдвэрлэлийг сайжруулах" төслийн хүрээнд 2018 онд ОХУ-ын Сибирийн бүс нутгийн жимс жимсгэнийн эрдэм шинжилгээ судалгааны байгууллагуудын туршлага судлах арга хэмжээг зохион байгуулж жимс жимсгэнэ тариалагч, судлаач, мэргэжлийн холбоодын 10 төлөөлөгч хамруулан жимс жимсгэнэ тариалах, үржүүлэх туршлага судлав. 2020 онд Бэлчээрийн менежмент төслийн хүрээнд ОХУ -д туршлага судлах жимс жимсгэнэ тариалагчдын мэргэжил ур чадварыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөж байна.	70%
32	3.12. Залгаж ургуулах аргаар үрт болон яст жимсний үржүүлэг хийх, талбайд болон хүлэмжид жимс, жимсгэнэ тариалах, мод, бутны таналт, тайралт, хэлбэржүүлэлтийг зохистой хийх арга технологийг эзэмшүүлэх чиглэлээр сургалтад хамруулж шинэ технологитой танилцах,	2018 - 2022		НҮБ-ийн ХХААБ-ын санхүүжилтээр 2018 онд Монголын жимс жимсгэнийн үндэсний холбооноос жимс жимсгэнэ тариалах, залгаж ургуулах, тайрч танах, өвчин, хортноос хамгаалах, зохистой дадал эзэмшүүлэх 4 удаагийн талбайн болон танхимын сургалтыг Төв, Дархан-уул болон Увс аймагт зохион байгуулж, 200 гаруй жимс жимсгэнэ тариалагчдыг хамруулж мэдлэг чадвар олгов. Тус яамны санхүүжилтээр “Хүлэмжинд жимс жимсгэнэ тариалах технологи” сургалтыг	100%

	туршлага судлах, тэдгээрийг нэвтрүүлэх;			Монголын хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн холбоо ТББ-тай гэрээ байгуулан Улаанбаатар хот, Сэлэнгэ аймагт сургалт зохион байгуулж 300 хүн хамруулж мэдлэг чадвар олгов. 2019 онд Монголын жимс жимсгэнийн үндэсний холбоотой хамтран “Чацаргана ба бусад жимс жимсгэнийн тариалалт, арчилгаа”, “Алим тариалах, залгуургын аргаар суулгац үржүүлэх”, “Чацаргана ба бусад жимс жимсгэнийн өвчин, хортон шавж, амьтан тэдгээрээс урьдчилан сэргийлэх ба тэмцэх арга”, “Жимс жимсгэнэ, гоёл чимэглэлийн мод бутны үржүүлэг”, “Жимс жимсгэнийн таримлын органик баталгаажуулалт” зэрэг 5 төрлийн сургалт зохион байгуулж 100 гаруй жимс жимсгэнэ тариалагчид, үйлдвэрлэгчдийн мэдлэг чадварыг дээшлүүлэв. АХБ-ны төслийн санхүүжилтээр Увс, Төв аймагт чацарганы тариаланд ХАА-н зохистой дадал нэвтрүүлэх, талбайд хавар, зуны улиралд хийх агротехникийн арга ажиллагааны сургалт зохион байгуулж нийт 138 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулав. Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн хүрээнд “Жимс жимсгэнийн тариалалт ба бүтээгдэхүүн хөгжүүлэлт” зөвлөгөөн, сургалт зохион байгуулан төсөлд хамрагдсан 6 аймаг нийслэлийн 100 гаруй жимс жимсгэнэ тариалагч, боловсруулагчид хамруулан мэдлэг чадварыг сайжруулав.	
33	3.13. Мэргэжлийн ахисан түвшний хөтөлбөрүүдийг боловсруулж, эрчимжсэн, дунд, урт хугацааны сургалтыг мэргэжлийн байгууллагыг түшиглэн явуулж, мэргэжилтэй ажилтан бэлтгэх;	2018 - 2022		Нэгдсэн үндэсний байгууллагын хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын санхүүжилтээр хэрэгжсэн “Монгол улсын жимс жимсгэнийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх” ТСП/MON/3605 төслийн хүрээнд Монголын жимс жимсгэнийн үндэсний холбоогоор “Монголын жимс жимсгэнийн салбарын стратегийн бодлогын баримт бичиг”-ийн төсөл боловсруулж танилцуулсан. Энэхүү баримт бичигт мэргэжлийн ахисан түвшний хөтөлбөрүүдийг эрчимжсэн дунд урт хугацааны сургалтын явуулахаар тусгасан. 2020 онд “Зах зээл бэлчээрийн менежмент” төслийн хүрээнд жимс жимсгэнийн технологи сэдвээр дунд хугацааны сургалт явуулахаар төлөвлөж байна.	40%
34	3.14. Жимс, жимсгэнийн аж ахуй эрхлэгч болон үйлдвэрлэгчдэд зориулсан мэргэжлийн зөвлөх, нэвтрүүлэх үйлчилгээ үзүүлэх багийг сонгон шалгаруулах, үйлдвэрлэгч, тариаланчдыг танхимын, талбайн, ажлын байран дахь сургалтад хамруулж, чадавхжуулах.	2018 - 2022		“Чацаргана боловсруулах үйлдвэрүүдэд хүнсний чанар аюулгүй байдлын олон улсын стандартыг нэвтрүүлэх” 84.5 сая төгрөгийн зөвлөх үйлчилгээний гэрээг Обзерв стар ХХК-тай байгуулан төсөлд оролцсон чацаргана боловсруулах 8 үйлдвэрт олон улсын чанарын удирдлагын тогтолцооны талаар цогц 18 төрлийн сургалт явуулж тус сургалтад идэвхтэй оролцож дотоодын баталгаажуулалтаар хангалттай үнэлгээ авсан “Еден” ХХК, “Увс Хүнс” ХК-д олон улсын баталгаажуулалтын байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэн ISO 9001 чанарын удирдлагын тогтолцооны гэрчилгээ авах шаардлага хангуулав. АХБ-ны төслийн санхүүжилтээр Увс, Төв аймагт чацарганы тариаланд ХАА-н зохистой дадал нэвтрүүлэх, талбайд хавар, зуны улиралд хийх агротехникийн арга ажиллагааны сургалт зохион байгуулж нийт 138 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулав.	70%
Зорилт-3-ын дундаж үнэлгээ					80.0%

4. Салбарын маркетингийн стратегийг боловсруулж, дотоод болон гадаадын хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг тодорхойлох, шинэ зах зээлд нэвтрэх ажлыг эхлүүлэх.

35	4.1. Хүн амд дотоодын жимс, жимсгэнийн бүтээгдэхүүнийг зохистой хэрэглэх дадал бий болгох, хэрэглээг нэмэгдүүлэх, ач тусыг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах;	2019 - 2022		<p>Хүнс, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарын ажил бүтээлийн амжилтыг дүгнэдэг, жил бүр уламжлал болгон, эдүгээ 14 дэх жилдээ зохион байгуулагдаж буй "Намрын ногоон өдрүүд-2019" нэгдсэн арга хэмжээний "Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн" үзэсгэлэн худалдаанд хүнсний үйлдвэрлэл эрхлэгч 120, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, тариалан эрхлэгч 250 гаруй аж ахуйн нэгж, иргэн, хоршоо оролцон, энэ 7 өдрийн турш борлуулалт нь 3.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос 1.5 дахин өсчээ. Үзэсгэлэн худалдаанд оролцсон ААНБ-ын шилдэг бүтээгдэхүүнийг батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэсэн ба шалгаруулах гол шалгуур үзүүлэлт нь хүний эрүүл мэндийг дэмжих үүрэгтэй байх, 2017 оноос мөрдөж буй сав баглаа боодол, шошгын стандартыг хангасан байдал зэргийг харгалзсан.</p> <p>Жимсний тариалан бүхий аймаг сумдад жил бүр "Алтан намар", "Эрүүл хүнс" зэрэг шинэ ургацын хүнсний ногоо, жимс жимсгэний үзэсгэлэн худалдаа зохион байгуулан өрхийн тариаланчид, жимс, жимсгэний үйлдвэрлэл эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулалтыг дэмжих ажлыг зохион байгуулж байна. Үзэсгэлэн худалдаанд оролцогчдоос шилдэг хүнсний ногоо, жимс жимсгэний үйлдвэрлэл эрхлэгч, шилдэг бүтээгдэхүүн зэрэг номинацуудаар шалгаруулан шагнаж, сурталчилж байна.</p>
36	4.2. Жимс, жимсгэнийн бүтээгдэхүүний борлуулалтыг төрийн худалдан авалтаар (боловсрол, эрүүл мэнд, батлан хамгаалах, хууль сахиулах байгууллагууд болон төрийн өмчийн аж ахуйн нэгж) дэмжих нөхцөлийг бүрдүүлэх;	2019		<p>Монгол Улсын Засгийн газраас 2019 оныг "Эх оронч худалдан авалтын жил"-ийн хүрээнд дотооддоо үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг худалдан авах, үндэсний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх, техник технологийн шинэчлэл хийх, олон улсын стандартын шаардлагад нийцсэн зах зээлд өрсөлдөх чадвартай бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, худалдан авалтыг нэмэгдүүлэх хүрээнд дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай 14 бүлгийн 155 нэр төрлийн жагсаалтыг шинэчлэн Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолоор баталсан. Эдгээр бараа, бүтээгдэхүүнийг аливаа тендерийн үндсэн нөхцөл болгож, худалдан авах бодлогыг Засгийн газар баримтлахаар тогтсон. Энэхүү жагсаалтад оруулах дотоодын жимс жимсгэнэ боловсруулах үйлдвэрийн бараа бүтээгдэхүүний нэр төрлийн судалгааг гаргаж ажлын хэсэгт хүргүүлсэн. Жагсаалтын 6.8. Ундаа, шүүс, өтгөрүүлсэн шүүс, жимсний охь, ханд; гэсэн бүтээгдэхүүн нэмэлтээр орж төрийн худалдан авалтад хамрагдах боломж бүрдсэн. Хүнс, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарын ажил бүтээлийн амжилтыг дүгнэдэг, жил бүр уламжлал болгон, эдүгээ 14 дэх жилдээ зохион байгуулагдаж буй "Намрын ногоон өдрүүд-2019" нэгдсэн арга хэмжээний "Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн" үзэсгэлэн худалдаанд хүнсний үйлдвэрлэл эрхлэгч 120, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, тариалан эрхлэгч 250 гаруй аж ахуйн нэгж, иргэн, хоршоо оролцон, энэ 7 өдрийн турш борлуулалт нь 3.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос 1,5 дахин өсжээ.</p>

				Үзэсгэлэн худалдаанд оролцсон ААНБ-ын шилдэг бүтээгдэхүүнийг батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэсэн ба шалгаруулах гол шалгуур үзүүлэлт нь хүний эрүүл мэндийг дэмжих үүрэгтэй байх, 2017 оноос мөрдөж буй сав баглаа боодол, шошгын стандартыг хангасан байдал зэргийг харгалзан үзсэн болохыг энд онцлон дурдах нь зүйтэй.	
37	4.3. Жимс, жимсгэнэ тариалагчид үйлдвэрлэсэн жимсээ чанар, стандартад нийцүүлэн зах зээлд гаргахад нь дэмжлэг үзүүлэх, борлуулалтын дотоод сүлжээ үүсгэх боломжийг бүрдүүлэх;	2019 - 2020		Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй “Хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг дэмжих” техник туслалцааны төслийн “Чацаргана” бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд “Чацарганын кластерын худалдаа-хамтын ажиллагааны тогтолцоо бүрдүүлэх, өртгийн сүлжээ үүсгэх” зөвлөх үйлчилгээний 50.0 сая төгрөгийн гэрээг Монголын жимс жимсгэнийн үндэсний холбоотой гэрээ байгуулан чацарганын кластерын тогтолцоо бий болгох, өртгийн сүлжээ үүсгэх ажлыг тариаланчид, боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчидтэй хамтран хэрэгжүүлж байна. Энэхүү ажлын хүрээнд кластерийн өртгийн сүлжээнд хамрагдах байгууллагын жагсаалт гарган 2019 оны 3 сарын 15-нд анхны уулзалтыг зохион байгуулж 6 аймаг, нийслэлийн 65 иргэн, аж ахуйн нэгж оролцов. Оролцогч талуудыг мэдээллээр хангах, санал бодлыг солилцох зорилгоор жимс жимсгэнийн холбооны Веб сайтаар тогтмол мэдээлэл түгээхийн зэрэгцээ "Mongolian seabuckthorn cluster initiative" facebook групп нээж ажиллуулж байна. 2019 онд чацаргана, жимс жимсгэнийн салбарын үр дүнтэй хамтын ажиллагаа, харилцаа холбоо, мэдээллийн солилцоог бий болгох зорилгоор энэ чиглэлээр ажиллаж байгаа олон улсын байгууллагууд, судалгааны байгууллагууд, төрийн бус байгууллагууд, үйлдвэрлэгчид, боловсруулагчид, зөвлөх компаниуд, тариалагчдын төлөөлөл нийт 33 оролцогч оролцсон уулзалтыг зохион байгуулж хамтын ажиллагаагаа цаашид уялдуулан ажиллахаар тохиролцов. Европын холбооны санхүүжилтээр хэрэгжиж буй “Монголын худалдааг дэмжих” TRAM төслийн хүрээнд 2019 онд “Чацарганын кластер байгуулах” төсөл хэрэгжүүлж чацарганын кластерт оролцогчдыг бүртгэлжүүлэн хамтын санамж бичиг байгуулан, удирдах зөвлөлийг сонгож хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган ажиллаж байна. Төслөөс 2020 оны 1 дүгээр сард Герман улсад зохиогдсон Green week хүнсний бүтээгдэхүүний олон улсын үзэсгэлэнд тус төслөөс 11.0 мянган еврогийн санхүүжилт зардал гарган стенд түрээслэж чацаргана боловсруулах Увс хүнс ХХК, Витафит ХХК, Хаан жимс ХХК, UFC групп гэсэн чацарганын 4 үйлдвэрийн бүтээгдэхүүнийг оролцуулж олон улсад сурталчлав.	100%
38	4.4. жимс, жимсгэнийн бүтээгдэхүүний гадаад зах зээлийн судалгаа хийх, түүнд тулгуурлан экспортын бүтээгдэхүүний маркетинг хөгжүүлэх;	2018 - 2020		АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй "Хөдөө аж ахуй хөдөөгийн хөгжил төслийн нэмэлт санхүүжилт" төслийн хүрээнд "Чацарганын бүтээгдэхүүний гадаад зах зээлийн судалгаа" зөвлөх үйлчилгээний ажлыг нээлттэй тендер шалгаруулан 109.6 сая төгрөгийн гэрээг Бодлогын шийдэл ТББ-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэв. Энэхүү ажлын хүрээнд Тайвань, Япон, БНСУ-ын чацарганын зах зээлийн судалгааг улс тус бүрээс 5 үйлдвэр	100%

				<p>нийт 15 үйлдвэр, бөөний худалдаа эрхлэгч 15, жижиглэнгийн худалдаа эрхлэгч 30 компани, нийт 500 гаруй иргэн хэрэглэгчээс судалгаа авч гүйцэтгүүлэн 3 үе шатны тайланг хэлэлцүүлэн хүлээн авсан. Судалгааны ажлаар эмхтгэл гаргаж Монгол улсын чацаргана боловсруулах үйлдвэрүүдэд танилцуулав. Энэхүү ажлын хүрээнд ОХУ, БНХАУ-ын чацарганын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспорт, Монгол улсын чацарганын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өнөөгийн байдал зах зээл, экспорт, импорт түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг салбарын бодлого, эрх зүй, чанар стандарт, тээвэр ложистик институт, технологи, судалгаа, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг хамруулан хийсэн нэн үр өгөөжтэй ажил болсон. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хот, Улаанцав, Тунглио хотуудад 2019 оны 9-р сард “Монгол-Хятадын экспо-2019”- үзэсгэлэн худалдаа зохион байгуулав. Үзэсгэлэнд чацаргана, жимс жимсгэнийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 3 аж ахуйн нэгж оролцов. 2019 оны 3 дугаар сард Хаан жимс ХХК –ын чацарганын бүтээгдэхүүнийг FOODEX JAPAN-2019 үзэсгэлэнд оролцоход санхүүгийн дэмжлэг үзүүлсэн ба бүтээгдэхүүн нь шилдэг бүтээгдэхүүний шагнал авав. Евродын холбооны TRAM төслийн хүрээнд 2020 оны 1 дүгээр сард Герман улсад зохиогдсон Green week хүнсний бүтээгдэхүүний олон улсын үзэсгэлэнд тус төслөөс 11.0 мянган еврогийн санхүүжилт зардал гарган стенд түрээсэлж чацаргана боловсруулах 4 үйлдвэрийн бүтээгдэхүүнийг оролцуулж олон улсад сурталчлав. Тус төслөөс 2020 оноос Герман улсад Монголд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний дэлгүүр нээхээр ажиллаж байна. Мөн Европын холбооны улсуудын чацарганын бүтээгдэхүүний судалгааг хийлгэх хүсэлт тавиад байна.</p>	
39	4.5. Жимс, жимсгэнэ, чацарганын болон үрийн холбоо зэрэг олон улсын байгууллагын туршлагаас суралцах, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, мэргэжилтэн, судлаачдыг чадавхжуулах, бүтээгдэхүүнээ сурталчлах;	2018 - 2022		<p>2018 оны 8 дугаар сард Турк улсын Станбул хотод зохион байгуулагдсан Олон улсын хүнсний ногоо, жимс жимсгэнийн таримлын нийгэмлэгийн ХХХ хуралд Монгол улсаас анх удаа 3 төлөөлөгч оролцож жимс жимсгэнийн судалгааны ажлаар мэдээлэл тавьж, туршлага солилцон, олон улсын мэргэжлийн байгууллага, судлаачидтай холбоо тогтоов. 2018 оны 9 дүгээр сард БНХАУ-ын Тайюань хотод зохион байгуулагдсан Олон улсын чацарганын холбооны VIII их хуралд 6 төлөөлөгч оролцож Монгол улсад явуулж буй чацарганын чиглэлийн эрдэм шинжилгээ, судалгааны зарим ажлын үр дүнг илтгэл тавьж хэлэлцүүлсний зэрэгцээ “Живэртийн оргил”, “Эко эрдэнэ” компаниуд бүтээгдэхүүнээ сурталчлав. 2019 оны 3 дугаар сард Хаан жимс ХХК –ын чацарганын бүтээгдэхүүнийг FOODEX JAPAN-2019 үзэсгэлэнд оролцоход санхүүгийн дэмжлэг үзүүлсэн ба бүтээгдэхүүн нь шилдэг бүтээгдэхүүний шагнал авав. Евродын холбооны TRAM төслийн хүрээнд 2020 оны 1 дүгээр сард Герман улсад зохиогдсон Green week хүнсний бүтээгдэхүүний олон улсын үзэсгэлэнд тус төслөөс 11.0 мянган еврогийн санхүүжилт зардал гарган стенд түрээсэлж чацаргана</p>	70%

				<p>боловсруулах 4 үйлдвэрийн бүтээгдэхүүнийг оролцуулж олон улсад сурталчлав. Цаашид Герман улсад Монгол бүтээгдэхүүн түүний дотор чацарганын бүтээгдэхүүн худалдах дэлгүүр нээхээр тус ажиллаж байна. Хүнс, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарын ажил бүтээлийн амжилтыг дүгнэдэг, жил бүр уламжлал болгон, эдүгээ 14 дэх жилдээ зохион байгуулагдаж буй "Намрын ногоон өдрүүд-2019" нэгдсэн арга хэмжээний "Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн" үзэсгэлэн худалдаанд хүнсний үйлдвэрлэл эрхлэгч 120, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, тариалан эрхлэгч 250 гаруй аж ахуйн нэгж, иргэн, хоршоо оролцон, энэ 7 өдрийн турш борлуулалт нь 3.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос 1.5 дахин өсчээ. Улаанбаатар дахь Тайваний эдийн засаг-худалдааны төлөөлөгчийн газар болон МҮХАҮТ-тай хамтран Тайваний Тайпэй хотод зохион байгуулагдсан Монгол-Тайваний бизнес эрхлэгчдийн форумд чацарганы үйлдвэрлийн төлөөлөл 4 ААН оролцож Монголын жимс жимсгэний үндэсний холбооны тэргүүн илтгэл тавьж Тайваний бизнес эрхлэгчид болон төр, банк, санхүүгийн байгууллагын төлөөлөлтэй уулзалтууд зохион байгуулав. Грек улсад 2020 оны 5-р сард зохион байгуулагдах олон улсын чацарганын холбооны их хуралд Монгол улсаас судлаачид, үйлдвэрлэгчдийн төлөөлөгчдийг оруулцуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.</p>	
40	4.6. Эх орны хөрсөнд тарьж ургуулсан экологийн цэвэр жимс, жимсгэнэ, чацарганын үнэ цэнийг дээшлүүлж, үйлдвэрлэгчид болон борлуулагч, хэрэглэгчдийг холбох биржийн арилжаа, үнэ хаялцуулах худалдаа зэрэг шинэлэг дэвшилтэт маркетинг нэвтрүүлэх, төрөлжсөн худалдааны төв байгуулж ажиллуулах.	2020		Хугацаа болоогүй 2020 оноос хэрэгжиж эхэлнэ	Үнэлэх боломжгүй
Зорилт-4-ийн дундаж үнэлгээ					82.0%